

БҮЛЭГ IV

ГАДААД СЕКТОР

- 4.1 ГАДААД ХУДАЛДАА
- 4.2 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ,
ГАДААД ӨР

ТОЙМ

Зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн голлох бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдсан нь үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг харуулж байна. Гэсэн хэдий ч дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал түүхэн дээд түвшинд хүрч, эрэлт буурсны улмаас нүүрсний үнэ огцом унасан нь экспортын орлогод голлох сөрөг нөлөө үзүүлэв. Нөгөө талаар дотоодын эрэлт саарснаар импортын өсөлт хязгаарлагдмал байв. Гэсэн хэдий ч экспортын орлогын бууралт илүү хүчтэй байсан тул урсгал дансны алдагдал тэлж, төлбөрийн тэнцэлд дарамт нэмэгдлээ.

БҮЛЭГ IV

4.1

ГАДААД ХУДАЛДАА

64. Гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан хэдий ч худалдааны эргэлт өмнөх оны мөн үеэс буурлаа. Монгол Улс 2025 оны эхний хагас жилийн байдлаар дэлхийн 145 улстай худалдаа хийж, худалдааны тэнцэл 1.0 тэрбум ам.долларын ашигтай гарсан хэдий ч нийт бараа эргэлт 12.1 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар буурлаа.

65. Экспортын орлогын өсөлт саарлаа. 2025 оны эхний хагас жилийн байдлаар Монгол Улсын экспорт 6.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.5 хувиар буурсан байна. Энэ бууралтад нүүрсний экспортын биет хэмжээ болон олон улсын зах зээл дээрх нүүрсний үнийн уналт голлон нөлөөлжээ. Цаашид экспортын голлох бүтээгдэхүүний биет хэмжээ өндөр түвшинд тогтвортой хадгалагдах төлөвтэй байгаа хэдий ч зэсийн баяжмалаас бусад голлох бүтээгдэхүүний хилийн үнэ гадаад орчны нөлөөгөөр буурахаар хүлээгдэж байна.

66. Гадаад орчноос шалтгаалан нүүрсний экспортын биет хэмжээ болон үнэ буурлаа. БНХАУ-ын коксжих нүүрсний олборлолт нэмэгдсэнээс гадна гангийн томоохон үйлдвэрүүд коксжих нүүрсний татан авалтаа удаашруулсан нь манай улсын нүүрсний экспортод сөргөөр нөлөөллөө. Үүний үр дүнд 2025 оны эхний хагас жил нүүрсний экспорт 37.9 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 6.8 хувиар буурсан байна. Мөн хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 40 хувиар буурснаар нүүрсний экспортын орлого 44 хувиар буурч, нийт экспортын өсөлтөд сөрөг нөлөө үзүүлээ. Цаашид, гадаад орчин дэх нүүрсний эрэлт тогтвортой байж биет хэмжээ нэмэгдэх хэдий ч хилийн үнэ сэргэх төлөвгүй байна.

67. Зэсийн баяжмал, төмрийн хүдрийн экспортын хэмжээ нэмэгдлээ. 2025 оны эхний хагас жилийн байдлаар зэсийн баяжмалын экспорт 1,054 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 34 хувиар, төмрийн хүдрийн экспорт 3,856 мянган тоннд хүрч өмнөх оны

Зураг 4.1. Экспорт



ГАДААД СЕКТОР



мөн үеэс 7 хувиар тус тус өссөн байна. Энэхүү өсөлт нь олборлолт нэмэгдсэн болон дэлхийн зах зээл дэх зэсийн эрэлт өндөр түвшинд хадгалагдаж байгаагаас шалтгаалаа. Харин олон улсын худалдаанд тодорхой бус байдал үүсгэж буй тарифын бодлого, худалдааны зөрчлүүдийн нөлөөгөөр газрын тосны экспорт 915 мянган тоннд хүрч, 12.9 хувиар буурсан байна. Цаашид зэсийн баяжмал болон төмрийн хүдрийн олборлолт тогтвортой нэмэгдэх төлөвтэй бөгөөд цэвэр зэсийн дэлхийн зах зээл дэх үнэ өсөх хандлагатай байна.

68. Экспортын хоригоос шалтгаалан зарим малын гаралтай бүтээгдэхүүний экспорт буурлаа.

Угаасан ноолуурын экспортыг хориглох Засгийн газрын шийдвэрийн хүрээнд 2025 оны эхний хагас жилийн байдлаар ноолуурын экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 72 хувиар буурсан байна. Мөн боловсруулах үйлдвэрлэлийн идэвх сул байсантай холбоотойгоор махны экспорт 25 хувиар, арьс ширний экспорт 70 хувиар тус тус буурчээ.

69. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны идэвх суларлаа.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний хагас жилийн байдлаар 2,362 мянган тонн нүүрсийг 175 сая ам.доллароор, 3,007 мянган тонн төмрийн хүдэр, баяжмалыг 184 сая ам.доллароор, 18.1 мянган

тонн зэсийн баяжмалыг 39 сая ам.доллароор, 18.3 мянган тонн хайлуур жоншны хүдэр, баяжмалыг 4.9 сая ам.доллароор тус тус арилжаалаад байна. 2024 оны хоёрдугаар улиралд уул уурхайн бүтээгдэхүүний биржээр нийт 212 арилжаа амжилттай хийгдсэн бол гуравдугаар улирлаас эхлэн арилжааны идэвх тасралтгүй буурсаар 2025 оны хоёрдугаар улиралд 85 арилжаа болж буурлаа.

70. Импортын өсөлтийн хурд саарлаа. 2024 онд эдийн засгийн идэвхжил өндөр байж, өрхийн орлого, зээл олголт нэмэгдсэнээр иргэд, аж ахуй нэгжийн худалдан авах чадвар сайжирч импортын бараа, бүтээгдэхүүний урсгал өндөр байв. Харин 2025 оны эхний хагас жилийн байдлаар импорт өмнөх оны мөн үеэс 150 сая ам.доллар буюу 2.8 хувиар өсөж, өсөлтийн хурд саараад байна.

71. Импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл:

нийт импортын өсөлтөд хэрэглээний бүтээгдэхүүн 6.3 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн бол, хөрөнгө оруулалтын зориулалттай машин механик тоног төхөөрөмж, барилгын материал 1.3 нэгж хувь, аж үйлдвэрийн орц 2.3 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн байна.

72. Хэрэглээний бүтээгдэхүүний импорт өндөр


хэвээр байна. Хэрэглээний бүтээгдэхүүний импортын 2.2 тэрбум ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 18 хувиар өсөв. Уг өсөлтөд суудлын автомашин болон хүнсний бүтээгдэхүүний импорт голлох нөлөөг үзүүллээ. Суудлын машины импорт 208 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 45 хувиар өслөө. 2025 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 10-аас дээш жилийн насжилттай тээврийн хэрэгсэлд шинээр улсын дугаар олгохгүй байхаар шийдвэрлэсэн. Нийт импортлож буй суудлын автомашины 50 орчим хувь нь 10-аас дээш жилийн насжилттай байдаг бөгөөд уг шийдвэртэй холбоотойгоор оны эхний хагаст суудлын машины импорт өндөр хэвээр байлаа. Мөн 2025 оны эхний хагас жилийн байдлаар өрхийн хүнсний хэрэглээ нэмэгдэж, хүнсний бүтээгдэхүүний импорт 12 хувиар өслөө.

73. Төслүүдийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, барилгын материалын импорт өслөө. Оны эхний хагас жилийн байдлаар байдлаар барилгын материалын импорт 670 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 12 хувиар өссөн байна. Мөн Эрдэнэбүрэн УЦС, Газрын тосны үйлдвэр, Сэлбэ дэд төв, Туулийн хурдны зам зэрэг томоохон

төслүүдийн бүтээн байгуулалтын нөлөөгөөр оны эцэст ч барилгын материалын импортын өсөлт өндөр хадгалагдахаар байна.

74. Худалдааны гол түнш орнуудын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт саарснаар импортын барааны зардал бага түвшинд байв. Импортын үнийн дүнгийн индекс 95.2 хувь буюу өмнөх оны мөн үеэс 4.8 хувиар буурсан байна. Худалдааны гол түнш орнуудын үнийн өсөлт саарснаар импортын барааны үнийн өсөлт саарлаа. Тухайлбал, манай улсын нийт импортын 38 хувийг бүрдүүлж буй БНХАУ-ын инфляц 2025 оны эхний хагас жилийн дунджаар -0.1 хувь байв. Харин нийт импортын 24 хувийг бүрдүүлж буй ОХУ-ын инфляц 2025 оны эхний улиралд дунджаар 10 хувь байгаа ч тус улсаас импортлож буй бүтээгдэхүүний 21 нэгж хувийг АИ-92 автобензин, 45 нэгж хувийг дизелийн түлш бүрдүүлж байна. ОХУ-ын Роснефть компанитай 2022 онд байгуулсан хэлэлцээрийн дагуу АИ-92 шатахууныг тогтвортой үнээр худалдан авч байгаа бөгөөд ОХУ-ны дизелийн түлшний үнэ буурч байгаа нь импортын барааны үнийн өсөлт бага байхад нөлөөллөө.

Зураг 4.2. Импорт



БҮЛЭГ IV

4.2

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ,
ГАДААД ӨР

75. Үйлчилгээний болон анхдагч орлогын дансны тэнцэл сайжирсан ч экспортын орлого буурснаар урсгал дансны алдагдал тэллээ. Энэ оны эхний 2 улиралд бараа, үйлчилгээний импорт агшиж, үйлчилгээний болон анхдагч орлогын дансны алдагдал өмнөх оны мөн үеэс буурлаа. Гэсэн хэдий ч барааны экспорт 1.2 тэрбум ам.доллараар буурснаар урсгал дансны алдагдал 1.7 тэрбум ам.долларт хүрч, төлбөрийн тэнцэл 450 сая ам.долларын алдагдалтай гарлаа.

76. Тээврийн болон барилгын үйлчилгээний алдагдал буурсан нь нийт үйлчилгээний дансны тэнцэл сайжрахад голлон нөлөөллөө. Үйлчилгээний дансны алдагдал 2025 оны эхний 2 улирлын байдлаар 1.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 205 сая ам.доллараар буурлаа. Үйлчилгээний дансны алдагдлын 38 хувь буюу 0.6 тэрбум ам.долларыг аялал жуулчлалын үйлчилгээ, 25 хувь буюу 0.4 тэрбум ам.долларыг бизнесийн бусад үйлчилгээ, 23 хувь буюу 0.3 тэрбум ам.долларыг тээврийн үйлчилгээний алдагдал бүрдүүлж байна. Оны эхний 2 улирлын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад ачаа тээврийн үйлчилгээний зардал 38 сая ам.доллараар буурч, нөгөө талаас орлого 65 сая ам.доллараар өссөнөөр тээврийн үйлчилгээний алдагдал өмнөх оны мөн үеэс 125 сая ам.доллараар буюу 27 хувиар буурсан үзүүлэлттэй гарлаа. Мөн өмнөх оны мөн үед 109 сая ам.доллар байсан барилга, угсралтын үйлчилгээний зардал 34 сая ам.долларт хүрч буурсан нь нийт үйлчилгээний дансны алдагдал буурахад эергээр нөлөөллөө.

77. Аялал жуулчлалын үйлчилгээний алдагдал өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдлаа. Нийт

аялал жуулчлалын үйлчилгээний дансны алдагдал 563 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурлаа. Үүнд, 2025 оны эхний 2 улирлын байдлаар эмчилгээтэй холбоотой аяллын үйлчилгээний зардал өмнөх оны мөн үеэс 82 сая ам.доллараар буюу 58 хувиар буурсан бол боловсролын үйлчилгээний төлбөр 44 сая ам.доллараар, бусад хувийн аяллын зардал 107 сая ам.доллараар тус тус өссөн нь нөлөөллөө. Улсын хилээр орсон жуулчдын тоо 2025 оны эхний 2 улиралд 328 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 83 мянгаар буюу 34 хувиар өссөн ба үүнд БНХАУ-ын жуулчид 38 мянгаар, БНСУ-ын жуулчид 13 мянгаар, ОХУ-ын жуулчид 7 мянгаар, Япон улсын жуулчид 4 мянгаар тус тус нэмэгджээ. Харин жуулчлалын зорилгоор гадаадад зорчсон Монгол иргэдийн тоо 2025 оны эхний 2 улиралд 202 мянгад хүрч, өмнөх оны мөн үеэс 46 мянгаар буюу 29 хувиар өссөн байна.

78. Бэлэн мөнгө ба харилцах дансны тэнцэл сайжирч, санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс нэмэгдлээ. Санхүүгийн дансны ашиг 2025 оны эхний 2 улирлын байдлаар 1.5 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 тэрбум ам.доллараар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнд өмнөх оны эхний хагаст төв банк своп хэлцлийн 0.6 тэрбум ам.долларын төлбөрийг гүйцэтгэсэнтэй холбоотойгоор бэлэн мөнгө ба харилцах дансны гарах урсгал өндөр байсан суурийн нөлөө голлон нөлөөллөө.

79. Шууд хөрөнгө оруулалтын орох урсгал буурлаа. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт орох урсгал 2025 оны эхний 2 улиралд 1,361 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 39 хувиар буюу 870 сая ам.доллараар буурлаа. Нийт шууд

хөрөнгө оруулалтын бууралтад уул уурхайн салбарын шууд хөрөнгө оруулалт 1,006 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 860 сая ам.доллаар буюу 46 хувиар буурсан нь голлон нөлөөллөө. Мөн мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны шууд хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 44 сая ам.доллаар, санхүү болон даатгалын үйл ажиллагааны шууд хөрөнгө оруулалт 4 сая ам.доллаар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Харин удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хөрөнгө оруулалт 26 сая ам.доллаар, худалдааны салбарын шууд хөрөнгө оруулалт 9 сая ам.доллаар тус тус өссөн байна.


80. Гадаад валютын нөөц нэмэгдсэн ч төгрөгийн ам.доллартой харьцах ханш суларлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 2 дугаар улирлын эцэст 5,206 сая ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 304 сая ам.доллаар буурсан ч өмнөх оны мөн үеэс 367 сая ам.доллаар өслөө. Төв банк 2025 оны эхний 2 улиралд өмнөх оны мөн үеэс 350 сая ам.доллаар их буюу 3,421 сая ам.долларыг зах зээлд дуудлага худалдаагаар нийлүүлсэн байна. Харин төгрөгийн ам.доллартой харьцах албан ханш 2025 оны эхний 2 улирлын эцэст 3,581 төгрөгт хүрч, оны эхнээс 160 төгрөгөөр суларлаа. Худалдааны түнш орнуудын валютаар жигнэсэн төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 2025 оны эхний 2 улирлын эцэст өмнөх оны мөн үеэс 8.1 хувиар, үнийн өөрчлөлтийн нөлөөг хассан бодит ханшийн индекс өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар тус тус суларлаа.

81. Нийт эдийн засгийн хадгаламж буурснаар урсгал дансны алдагдал тэллээ. Урсгал дансны тэнцлийг тухайн улсын нийт хадгаламж болон хөрөнгө

оруулалтын зөрүүгээр мөн тайлбарладаг. Сүүлийн 10 жилийг авч үзвэл манай улсын хөрөнгө оруулалтын хэрэгцээ хадгаламжаас давж, 2023 оноос бусад онд урсгал данс алдагдалтай байсан. Сүүлийн 4 улирлын нийлбэрээр тооцсон урсгал дансны алдагдал 2025 оны эхний 2 улирлын эцэст ДНБ-ий 13 хувьтай тэнцэж, өмнөх оны мөн үеэс 9 нэгж хувиар нэмэгдлээ. Үүнд хэрэглээний өсөлтөөс үүдэлтэйгээр хадгаламж өмнөх оны мөн үеэс 6.3 нэгж хувиар буурч, нөгөө талаас хөрөнгө оруулалт 2.2 нэгж хувиар өссөн нь нөлөөллөө. Нийт эдийн засгийг төр болон хувийн хэвшилд хуваан харвал, Засгийн газар болон хувийн хэвшлийн хадгаламжийн бууралт хөрөнгө оруулалтын өсөлтөөс давсан үзүүлэлттэй байна.

82. Гадаад хөрөнгө оруулалтын позиц сул хэвээр байна. Гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгө болон Монгол Улс бусад улсад төлөх үүрэг бүхий өр төлбөрийн зөрүүг харуулдаг гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц 2025 оны эхний 2 улирлын эцэст -46.0 тэрбум ам.долларт хүрч, ДНБ-ий -189 хувьтай тэнцэж байна. 2025 оны эхний 2 улирлын байдлаар Монгол Улсад байршиж буй гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн дүн 56.1 тэрбум ам.долларт хүрсэн нь гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгөөс 5.5 дахин их байна. Гадаад улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 61 хувь буюу 34.3 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, 26 хувь буюу 14.3 тэрбум ам.доллар нь зээл байна. Харин гадаад улсад байршиж буй Монгол Улсын эзэмшлийн санхүүгийн хөрөнгийн 51 хувь буюу 5.2 тэрбум ам.доллар нь нөөц хөрөнгө байна.

Зураг 4.3. Урсгал болон санхүүгийн дансны тэнцэл, төгрөгийн ханш



83. Төрийн болон хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдэл өслөө. Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2025 оны 2 дугаар улирлын эцэст 39.6 тэрбум ам.доллар болж, өмнөх улирлын эцсээс 1.6 тэрбум ам.доллараар буюу 4.1 хувиар өслөө. Сектороор харвал, өмнөх улирлаас төв банкны гадаад өр 368 сая ам.доллараар, Засгийн газрын гадаад өр 203 сая ам.доллараар, хадгаламжийн байгууллагын гадаад өр 210 сая ам.доллараар, бусад хувийн хэвшлийн гадаад өр 999 сая ам.доллараар тус тус өссөн байна. Зураг 4.4. Урсгал данс, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өр

84. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдлийн өсөлтийн дийлэнхийг санхүү болон уул уурхайн салбар бүрдүүлээ. Хувийн хэвшлийн гадаад өрийн үлдэгдлийн өсөлтийн 75 хувь буюу 749 сая ам.долларыг уул уурхайн салбар, 19 хувь буюу 187 сая ам.долларыг санхүү болон даатгалын салбар бүрдүүлсэн байна. Бусад салбаруудын хувьд, удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа, тээвэр, мэдээлэл, холбоо, худалдааны салбаруудын гадаад өрийн үлдэгдэл өмнөх улирлаас өссөн бол боловсруулах, эрчим хүч, үл хөдлөх хөрөнгө зэрэг салбаруудын гадаад өрийн үлдэгдэл буурсан үзүүлэлттэй байна.

85. Улсын нийт гадаад өрийн дийлэнхийг шууд хөрөнгө оруулалт болон зээл бүрдүүлж байна. Улсын нийт гадаад өрийн үлдэгдлийн 45 хувь буюу 18.0 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалттай компанийн өглөг, 36 хувь буюу 14.3 тэрбум ам.доллар нь зээл, 10 хувь буюу 4.0 тэрбум ам.доллар нь бонд байна. Тэр дундаа, зээлийн үлдэгдлийн 46 хувь нь Засгийн газар болон төв банкны зээл, 54 хувь нь хувийн хэвшлийн зээл байна.

86. Гадаад өрийн динамик ханш, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. ДНБ-д харьцуулсан гадаад өрийн хэмжээ ханшийн өөрчлөлт, урсгал дансны тэнцлийн шокуудад эмзэг байна. Суурь төсөөлөлтэй харьцуулахад дунд хугацаанд гадаад өр болон ДНБ-ий харьцаа урсгал дансны үндсэн тэнцэл 1 стандарт хазайлтаар буурахад 10.2 нэгж хувиар, төгрөгийн ханш 10 хувиар сулрахад 18.3 нэгж хувиар тус тус өсөхөөр байна.

Зураг 4.4. Урсгал данс, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад өр

